



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 4/262.

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6, 6 дугаар зүйлийн 6.2.9, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 203 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд хуулийг дагалдан гарах эмийн үнийн зохицуулалтын эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Ажлын хэсгийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Г.Цэцэнсанаа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын дарга (Б.Батзориг)-д даалгасугай.

ДАРГА Д.НАРАНТУЯА



Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20.12 оны 11 дугаар сарын 11-ны
өдрийн 11 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Цэцэнсанаа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын дарга)
Гишүүд:	Н.Гэрэлт-Од, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Стратеги удирдлагын хэлтсийн ахлах шинжээч Н.Цэрэнсамбуу, Төрийн худалдан авах ажиллагааны газрын Цахим худалдан авах ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга (Зөвшилцсөнөөр) О.Батмөнх, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон тооны гишүүн (Зөвшилцсөнөөр) М.Долгион, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Гантуяа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Эдийн засаг төлөвлөлт, судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн (Зөвшилцсөнөөр) Л.Амартүвшин, Гаалийн ерөнхий газрын Гаалийн хяналт шалгалтын газрын Гаалийн улсын байцаагч (Зөвшилцсөнөөр) Б.Халиун, Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын татварын улсын байцаагч (Зөвшилцсөнөөр) А.Номиндарь, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын мэргэжилтэн Д.Очирпүрэв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв улсын үйлдвэрийн газрын Систем төлөвлөлт, статистикийн албаны менежер (Зөвшилцсөнөөр) Д.Отгонтуяа, Азийн хөгжлийн банкны төслийн зөвлөх (Зөвшилцсөнөөр) А.Дарьбал, Эм хангамжийн байгууллагуудын холбооны гүйцэтгэх захирал (Зөвшилцсөнөөр) И.Балжинням, Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" холбооны гүйцэтгэх захирал (Зөвшилцсөнөөр)
Нарийн бичгийн дарга:	Э.Мядагмаа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын мэргэжилтэн

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20.12 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХУУЛИЙГ ДАГАЛДАН ГАРАХ ЭМИЙН ҮНИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт болон тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхийн тулд иргэдэд хэрэгцээтэй байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүгийн хүндрэл бэрхшээлгүйгээр авах нөхцлийг бүрдүүлэх нь Засгийн газрын нэн түрүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэг юм. Энэхүү арга хэмжээний нэг гол хүчин зүйл нь эмийн үнийг зохицуулах оновчтой бодлого хэрэгжүүлэхэд оршино.

Монгол улсад 2017 онд Олон улсын эрүүл мэндийн үйл ажиллагааны байгууллагын (Health Action International) баталгаат аргачлалын дагуу хийгдсэн “Монгол улсын эмийн үнэ, хүртээмж, худалдан авах боломж, үнэ бүрдлийн судалгаа”-ны дүнгээр эмийн хүртээмж 58% байсан нь ДЭМБ-ын 80%-тай байх гэсэн зорилгод хүрээгүй. Мөн аргачлалын дагуу улсын салбарт эмийн медиан үнийн харьцаа (МҮХ) нэг ба түүнээс доош байхад худалдан авалт оновчтой хэмээн үздэг бол дээрх судалгаагаар медиан 2.03 гарсан нь олон улсын дунджаас 2 дахин илүү байна.

“Дэлхий нийтийн эм, вакцины дутагдалтай байдлыг арилгах” сэдвээр 2018 онд болсон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 71 дүгээр чуулганаар эмийн үнийн бодлогын хувьд улс орнууд илүү их улс төрийн хүсэл эрмэлзэл гаргах, дотоодын санхүүгийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, иргэний шууд төлөх зардлыг багасгахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, тухайлбал ерөнхий нэршлийн эмийн хэрэглээг дэмжих, эмийн хангамжийн шатлал бүрд эмийн үнэд нэмэгдэх хэмжээг тогтоох болон бусад эмийн үнийн зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэхийг уриалсан.

Иймд иргэдийг эрүүл мэндийн зардлаас үүдэлтэй санхүүгийн эрсдлээс хамгаалах, эмийн хүртээмж болон худалдан авах боломжийг нэмэгдүүлэхэд эмийн үнийг зохицуулах зайлшгүй шаардлага, хэрэгцээ тулгараад байна.

Хоёр. Зорилго

Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд хуулийг дагалдан гарах эмийн үнийн зохицуулалтын эрх зүйн баримт бичгийг боловсруулахад оршино.

Гурав. Үйл ажиллагаа

1. Эмийн үнийн зохицуулалтад оролцогч талуудын чиг үүрэг, оролцооны талаар мэдээлэл солилцох;
2. Зайлшгүй шаардлагатай эм, өнчин эмийн үнийн хяналт, зохицуулалт хийх журмын төсөл боловсруулах;
3. Журмын төсөлд оролцогч талуудын саналыг тусгах;

Дөрөв. Хэрэгжүүлэгч байгууллага

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар

Тав. Хамтран ажиллах байгууллага

Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Шударгаа өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв улсын үйлдвэрийн газар, Азийн хөгжлийн банк, Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" холбоо, Эм хангамжийн байгууллагуудын холбоо

Зургаа. Хэрэгжүүлэх хугацаа

2022.11.15 - 2022.12.15

Долоо. Хүрэх үр дүн

1. Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний үнийн хяналт, зохицуулалт хийх журмын төслийг боловсруулсан байна.
2. Журмын төсөлд оролцогч талуудын саналыг тусгаж, нэгтгэн Эрүүл мэндийн яаманд 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлсэн байна.